

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
2. Үйлчилгээний албан хаагчдад ур чадварын үнэлгээ хийгээгүй, ур чадварын нэмэгдэл олгоогүй.	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



63129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiy@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.АРМАНБЕК ТАНАА

2022.02.25 № 239
танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, санхүүгийн тайлан дахь 717.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

2. Нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөөгүй, нярвын тооцоог хийгээгүй, нярвын бараа материалын тайлангийн орлого, зарлагын дүнгүүд санхүүгийн тайлантай зөрүүтэй байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6 гэсэн заалтууд болон УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, толилуулга, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгыг заавар аргачлалтын дагуу бэлтгэж ирүүлээгүй.

Аудитын гол асуудал

Өмч хөрөнгийн бүртгэл тооллого, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй.

Бусад асуудлын хэсэг

Аж ахуйн бараа материалын тайланг аудитад ирүүлээгүйгээс орлого, зарлагын тооцоог хийх боломжгүй, төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс гаргасан 6-10 дугаар сарын цалингийн цэсийн дүн зөрүүтэй, цалингийн цэсээр тооцоо хийх боломжгүй, программд нэвтрэх эрх нь хязгаарлагдсан зэргээр хамрах хүрээ хязгаарлагдсан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>137,492,247.00</u>	<u>108,723,537.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	16,299,931.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	16,299,931.00
3121	Төгрөг	-	16,299,931.00
31211	Төрийн сангийн харилцах	-	16,299,931.00
31212	Монгол банкин дахь харилцах	-	-
33	АВЛАГА	800,000.00	2,668,369.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	800,000.00	2,668,369.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	136,692,247.00	89,755,237.00
354	Хангамжийн материал	136,692,247.00	89,755,237.00
35410	Бичиг хэргийн материал	4,272,650.00	4,850,000.00
35420	Аж ахуйн материал	68,301,680.00	75,999,280.00
35460	Хүнсний материал	41,401,917.00	8,905,957.00
35470	үдийн хоолны материал	22,716,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,002,036,945.01</u>	<u>3,089,306,396.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,002,036,945.01	3,089,306,396.07
392	Биет хөрөнгө	2,965,997,945.01	3,053,342,396.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,973,153,118.00	2,977,153,118.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(185,611,388.96)	(238,055,438.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	258,013,896.00	338,944,996.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(239,825,682.77)	(248,454,635.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	221,990,014.00	276,540,990.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(176,417,452.26)	(177,557,075.48)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	13,000,000.00	13,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,911,890.00	11,986,890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39217	Ном	99,783,551.00	99,783,551.00
393	Биет бус хөрөнгө	36,039,000.00	35,964,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(675,000.00)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,964,000.00	35,964,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,139,529,192.01</u>	<u>3,198,029,933.07</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,972,248.00</u>	<u>1,415,606.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,972,248.00	1,415,606.00

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

413	Өглөг	2,972,248.00	1,415,606.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,852,248.00	1,415,606.00
4136	Бусад өглөг	120,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	120,000.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,136,556,944.01</u>	<u>3,196,614,327.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,136,556,944.01	3,196,614,327.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,988,658,085.00	1,988,658,085.00
512	Хуримтлагдсан үр дүн	138,387,046.89	198,444,429.95
51210	Өмнөх үеийн үр дүн	(83,862,498.83)	138,387,046.89
51220	Тайлант үеийн үр дүн	222,249,545.72	60,057,383.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,009,511,812.12	1,009,511,812.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,139,529,192.01</u>	<u>3,198,029,933.07</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,387,848,693.00	2,740,818,776.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	973,912.00	9,577,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	973,912.00	9,577,500.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	973,912.00	9,577,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	973,912.00	9,577,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,386,874,781.00	2,731,241,276.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,966,285,700.00	2,352,136,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,352,136,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,966,285,700.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,225,675.00	1,620,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,225,675.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,620,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	411,363,406.00	377,484,776.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,101,100.00	297,915,300.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	238,262,306.00	79,569,476.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,165,599,147.28	2,680,761,392.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,165,599,147.28	2,680,761,392.94

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,118,642,547.28	2,547,697,403.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,519,532,875.00	1,807,901,900.00
210101	Үндсэн цалин	1,435,322,775.00	1,373,623,135.82
210102	Нэмэгдэл	-	361,626,533.69
210104	Урамшуулал	84,210,100.00	72,652,230.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,626,100.00	224,741,531.00
210201	Тэтгэврийн даатгал	146,810,900.00	153,044,731.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,453,800.00	17,915,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,363,100.00	14,331,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,090,700.00	3,620,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,907,600.00	35,829,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,101,100.00	192,701,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,495,391.00	8,587,647.00
210302	Түлш, халаалт	166,605,709.00	184,113,353.00
210303	Цэвэр, бохир ус	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	13,474,021.00	-
210401	Бичиг хэрэг	2,324,925.00	
210402	Тээвэр, шатахуун	1,847,596.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,749,900.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	630,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,921,600.00	
2105	Нормативт зардал	124,961,823.00	195,930,688.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,229,687.00	
210502	Хоол, хүнс	118,622,664.00	195,930,688.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,109,472.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	825,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	825,000.00
2107	Томилолт, зочны зардал	604,800.00	-
210702	Дотоод албан томилолт	604,800.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,476,000.00	8,566,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	756,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,566,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,865,828.28	117,031,284.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,426,310.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,942,388.00	15,317,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,923,440.28	62,287,624.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,956,600.00	133,063,989.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,956,600.00	133,063,989.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,956,600.00	133,063,989.00

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		-
213304	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>222,249,545.72</u>	<u>60,057,383.06</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>222,249,545.72</u>	<u>60,057,383.06</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,148,612,475.00</u>	<u>2,651,671,800.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,148,612,475.00</u>	<u>2,651,671,800.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,966,285,700.00	2,352,136,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,352,136,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,966,285,700.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,225,675.00	1,620,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,225,675.00	1,620,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	<u>173,101,100.00</u>	<u>297,915,300.00</u>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	173,101,100.00	297,915,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,147,253,475.00</u>	<u>2,565,384,269.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,147,253,475.00</u>	<u>2,565,384,269.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>2,078,312,475.00</u>	<u>2,472,200,469.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,522,916,900.00	1,809,399,000.00
210101	Үндсэн цалин	1,438,706,800.00	1,375,120,174.82
210102	Нэмэгдэл	223,200.00	361,626,594.69
210104	Урамшуулал	83,986,900.00	72,652,230.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<u>208,626,100.00</u>	<u>225,112,800.00</u>

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	146,810,900.00	153,453,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,453,800.00	17,915,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,363,100.00	14,331,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,090,700.00	3,582,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,907,600.00	35,829,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,101,100.00	192,701,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,495,391.00	8,587,647.00
210302	Түлш, халаалт	166,605,709.00	184,113,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,044,000.00	-
210401	Бичиг хэрэг	529,200.00	
210402	Тээвэр, шатахуун	830,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,749,900.00	
210404	Ном, хэвлэл	756,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	630,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,548,900.00	
2105	Нормативт зардал	145,781,600.00	182,598,869.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	645,100.00	
210502	Хоол, хүнс	141,021,500.00	182,598,869.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,115,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	604,800.00	-
210702	Дотоод албан томилолт	604,800.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,356,000.00	8,566,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	756,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		8,566,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,881,975.00	52,722,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		37,334,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,881,975.00	15,388,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,941,000.00	93,183,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,941,000.00	93,183,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,941,000.00	93,183,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,359,000.00</u>	<u>86,287,531.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,359,000.00	69,987,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,359,000.00	69,987,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,359,000.00	69,987,600.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,359,000.00	69,987,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,359,000.00)</u>	<u>(69,987,600.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	16,299,931.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		16,299,931.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	138,387,046.89	3,136,556,944.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	138,387,046.89	3,136,556,944.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	138,387,046.89	3,136,556,944.01
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	138,387,046.89	3,136,556,944.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	138,387,046.89	3,136,556,944.01
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D08	Тайлант үеийн үр дүн			60,057,383.06	60,057,383.06
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	198,444,429.95	3,196,614,327.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,650,051,800.00	2,633,751,869.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,650,051,800.00	2,633,751,869.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,556,868,000.00	2,540,568,069.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,809,399,000.00	1,809,399,000.00
210101	Үндсэн цалин	1,463,920,800.00	1,375,120,174.82
210102	Нэмэгдэл	278,153,700.00	361,626,594.69
210104	Урамшуулал	67,324,500.00	72,652,230.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	225,112,800.00	225,112,800.00
210201	Тэтгэврийн даатгал	153,453,100.00	153,453,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,915,100.00	17,915,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,331,800.00	14,331,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,582,900.00	3,582,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,829,900.00	35,829,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,701,000.00	192,701,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,278,300.00	8,587,647.00
210302	Түлш, халаалт	184,422,700.00	184,113,353.00
2105	Нормативт зардал	182,676,700.00	182,598,869.00
210502	Хоол, хүнс	182,676,700.00	182,598,869.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,245,700.00	8,566,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,245,700.00	8,566,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,632,800.00	121,090,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,264,300.00	102,721,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,368,500.00	18,368,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,183,800.00	93,183,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,183,800.00	93,183,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	93,183,800.00	93,183,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,650,051,800.00	2,650,051,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,352,136,500.00	2,352,136,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,352,136,500.00	2,352,136,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	297,915,300.00	297,915,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	297,915,300.00	297,915,300.00

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		16,299,931.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	119	132
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	74	86
620003	Үйлчлэх ажилтан	44	45
620004	Гэрээт ажилтан		-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,225,675.00	1,620,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,225,675.00	1,620,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,225,675.00	1,620,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	630,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	630,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,595,675.00	1,620,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,595,675.00	1,620,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,225,675.00	1,620,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,225,675.00	1,620,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,225,675.00	1,620,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн, сурлагын хоцрогдлыг арилгах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш бүр салбар секцээр болон багаар хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн хөгжлийн бүлэг үүсгэж ажиллах
- Бусад аймаг, сумын нэг, нэг сургууль, дотуур байрны тэргүүн туршлагыг сургалт, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Монгол хэлний багш нарын ур чадварыг сайжруулахад анхаарч, суралцагчдын ярианы болон бичгийн чадварыг дээшлүүлэх
- Сургуулийн үйл ажиллагаанд асран хамгаалагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор аймгийн БШУГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас сургуулийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 49.6 сая төгрөгийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага өгөгдсөн байна. Актын төлбөрийн бүрэн барагдаагүй байна. Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна. Энэ нь аудиторын дүгнэлтийг өөрчлөх үндэслэл болсон.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь сургуулийн захирлын 2019 оны А/20 тоот тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг батлан мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58.5 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		16,299.9	16,299.9
Авлага	800.0	2,668.4	1,868.4
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	136,692.2	89,755.2	(46,937.0)
Үндсэн хөрөнгө	3,002,036.9	3,089,306.4	87,269.5
Нийт хөрөнгө	3,139,529.2	3,198,029.9	58,500.7
Өр төлбөр	2,972.2	1,415.6	(1,556.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,136,556.9	3,196,614.3	60,057.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,139,529.2	3,198,029.9	58,500.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна..

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 16.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний зардлуудын хэмнэлт байна. Дээрх зардлуудаас бараа үйлчилгээний зардлын хэмнэлт 12.5 сая төгрөг байна.

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Оны эхний авлага 1.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсдаас авах урьдчилгаа, НДШ-ийн авлагаар нэмэгдсэн. Урьдчилж гарсан зардал данс оны эхэн, эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын данс 46.9 сая төгрөгөөр буурсан нь үдийн цай болон хоол хүнсний материалын үлдэгдэл буурсан, аж ахуй, бичиг хэргийн үлдэгдэл 8.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой ба тайлант онд 2.1 сая төгрөгийн материал үнэ төлбөргүй, 7.5 сая төгрөгийн үдийн цайны материалаас аж ахуйн материалд шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 6 дугаар сард хийсэн баримтын шалгалтаар улсын байцаагчийн 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 18-03/15 тоот албан шаардлагыг үндэслэн бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэлтэй үдийн цайны материалын үлдэгдлээс аж ахуйн бараа материалын дансанд 7,477.5 мянган төгрөгийг, үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж дансанд 5,238.5 мянган төгрөгийг шилжүүлэн, хүнсний материалын дансны үлдэгдлээс 23,470.3 мянган төгрөгийг тооллогоор дутагдсан гэж нийтдээ 36,186.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайлангаар бууруулж тайлагнаж ирүүлсэн.

Үндсэн хөрөнгийн данс 87.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 70.0 сая, 74.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө, 5.3 сая төгрөгийн бараа материалын тайлангаас шилжүүлэн авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 62.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Сургуулийн захирлын 2022 оны А/19 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хагас дутуу хөтөлсөн, тооллогын дүнг хэлэлцэж тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь 717.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Өр төлбөр дансны оны эхний 3.0 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст 1.4 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгтэй гарсан.

Тайлант онд 60.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 60.1 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,897.0 сая, орон нутгийн төсвөөс 240.0 сая, нийт зарлагыг 3,137.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 486.9 сая төгрөгөөр бууруулж 2,650.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,837.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 294.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос нийтдээ 3,134.7 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,837.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 294.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 3.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулж оны эцэст 84.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,050.3 сая төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь хоол, үдийн цай, бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80112-Нийтлэг үйлчилгээ	297,915.3	297,915.3	-	100.0
2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	4,898.3	4,898.3	-	100.0
3	80312-Сургалт семинар	2,449.1	2,449.1	-	100.0
4	80823-Эрүүл мэндийн арга хэмжээ	5,633.0	5,633.0	-	100.0
5	81801-Үдийн цай	93,183.8	93,183.8	-	100.0
6	81806-Дотуур байрны үйлчилгээ	363,352.5	363,274.7	(77.8)	100.0
7	81816-Хүүхдэд ээлтэй орчин	76,425.0	64,842.8	(11,582.2)	84.8
8	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	11,021.1	10,060.9	(960.2)	91.3
9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,560,140.2	1,556,460.5	(3,679.7)	99.8
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	235,033.5	235,033.5	-	100.0
	Дүн	2,650,051.8	2,633,751.9	(16,299.9)	99.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь тайлант онд 1.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилт хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний БӨА-2022/80/НА-СТА-ТШЗ

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,165.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 21.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: нормативт зардлыг 0.08 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 3.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 12.5 сая нийт 16.3 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 951.0 сая төгрөгийн 41 гүйлгээг дуу мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 1.0 сая төгрөгийн 2 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 62.1 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар 22.7 сая төгрөгийн акт тогтоосныг барагдуулсан, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, 3 заалттай зөвлөмж өгөгдсөн хэрэгжүүлээгүй, биелэлт 66.7 хувьтай байна.

Хүснэгт:4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	22,716.00	1	22,716.00	100
Албан шаардлага	1	2,590.00	1	2,590.00	100
Зөвлөмж	3	70,394.20	-	-	-
Нийт дүн	5	95,700.20	2	25,306.00	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орон тооны гүйцэтгэл, цалин хөлс, хоол, үдийн цайны төсвийн зарцуулалт, бараа материалын тайлан гаргалт, тооллого, тооцоо хийсэн байдал, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, төсвийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналтын хэрэгжилтийг анхаарах шаардлагатай.

Аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй, эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 2054.1 сая төгрөгийн зөрчил илэрч 3.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2048.6 сая төгрөгийн албан шаардлага өгөгдлөө. Үүнээс сургуулийн нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Сургуулийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар 01-ны өдрийн А/35, А/10/9 дүгээр хамтарсан тушаалыг баримтлалгүйгээр сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Б/101 тоот захирамжаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны хүчингүй болсон 362/112/183 дугаар хамтарсан тушаалыг үндэслэж 2022 оны санхүүгийн жилд 2.4 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хууль бусаар авсан байна.

2. Нягтлан бодогч нь Засгийн газрын 192 дүгээр тогтоолоор батлагдсан 2022 оны 5 дугаар 01-ний өдрөөс дагаж мөрдөх үндсэн цалингийн шатлалаар 1, 2, 4 дүгээр саруудад 0.3 сая төгрөгийн /ур чадвар, удаан жил хувь нэмэгдсэн дүнгээр/ цалинг илүү бодож авсан.

3. Нэр бүхий 3 ажилтанд олгосон 0.6 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй байна.

5.2 Албан шаардлага:

Аудитаар дараах зөрчлүүдэд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж аж ахуйн албаны дарга 1, нярвын 1 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс 15.5 сая төгрөгийн үргүй зардал гаргасан.

2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 951.0 сая төгрөгийн 41 гүйлгээг дутуу мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 1.0 сая төгрөгийн 2 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 62.1 хувьтай байна.

Аудитаар дараах зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Сургуулийн захирлын 2022 оны А/19 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хагас дутуу хөтөлсөн, тооллогын дүнг хэлэлцэж тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь 717.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй.

2. Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 6 дугаар сард хийсэн баримтын шалгалтаар бэлэн бүтээгдэхүүн дансанд бүртгэлтэй үдийн цайны материалын үлдэгдлээс аж ахуйн бараа материалын дансанд 7.5 сая төгрөгийг, үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж дансанд 5.2 сая төгрөгийг шилжүүлэн, хүнсний материалын дансны үлдэгдлээс 23.5 сая төгрөгийг тооллогоор дутагдсан гэж нийтдээ 36.2 сая төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайлангаар бууруулж тайлагнаж ирүүлсэн.

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Тайлант онд жилийн үдийн цайнд 59,505 хүүхдэд 97.2 сая төгрөгийн зарцуулж 1 хүүхдэд ногдох нормыг 7.9 сая төгрөгөөр, дотуур байрны хүүхдийн хоолонд 45,707 хүүхдэд 172.8 сая төгрөгийг зарцуулж 1 хүүхдэд ногдох хоолны нормыг 13.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн.

4. Мөнгөн гүйлгээний тайлан, бараа материалын тайлан, нярвын тайлан дахь Үдийн цай, хоолны зардлын орлогын дүнгүүд болон Үр дүнгийн тайлан, бараа материалын тайлан, нярвын тайлангаарх зарлагын дүнгүүд хоорондоо зөрүүтэй, аудитын хугацаанд аж ахуйн бараа материалын тайланг ирүүлээгүй зэргээс тайлант оны орлого, зарлагын тооцоог хийх боломжгүй.

5. Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс гаргасан цалингийн цэсээр тооцоо хийх боломжгүй, 6-10 дугаар сарын цалингийн цэсийн дүнгүүд зөрүүтэй, 9 дүгээр сарын бодогдсон цалин 152.8 сая төгрөгийн цалингаас НДШ, цалингийн ашгийн суутгал хийгээгүй тавьж олгосон, ээлжийн амралтын олголтууд зөрүүтэй, цалингийн урьдчилгааны тооцоо хийх боломжгүй, программд нэвтрэх эрх нь хязгаарлагдсан. Цалингийн цэсийн тооцоолол дутуугаас цалингаас суутгасан 187.2 сая төгрөгийн НДШ, 118.9 сая төгрөгийн цалингийн татварын тооцоо хийх боломжгүй байна.

6. Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нягтлан бодогч нь Засгийн газрын 192 дүгээр тогтоолоор батлагдсан үндсэн цалинг илүү бодож авсан, 3 ажилтанд олгосон цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, Сургуулийн	1	3300.1	1	3300.1								

Сагсай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

захирал журам зөрчиж ур чадварын нэмэгдэл авсан, нягтлан бодогч ур чадварын нэмэгдлийг тогтоосон хэмжээнээс илүү авсан.									
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр 717.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй		717,228.1						717,228.1	
Үдийн цай, хүнсний материалын үлдэгдлээс тооллогоор дутагдсан гэж 36.2 сая төгрөгийн бараа материалыг зарлага гаргасан		36,186.3						36,186.3	
Үдийн цай 7.9 сая төгрөгөөр, дотуур байрны хүүхдийн хоолны нормыг 13.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн. Бараа материалын тайлан, санхүүгийн тайлангийн орлого, зарлагын дүнгүүд зөрүүтэй	1	21,859.6					1	21,859.6	
Цалингийн зардлыг цэсээр ажиллагсдаас суутгасан 189.2 сая төгрөгийн НДШ, 118.9 сая төгрөгийн цалингийн ашгийн тооцоо хийх боломжгүй		303,038.2						303,038.2	
Дүн	2	1,081,612.3	1	3300.1			1	1,078,312.2	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 41 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй	1	951,981.4			1	951,981.4			
Дүн	1	951,981.4			1	951,981.4			
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
“Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж ахуйн албаны дарга 1, нярвын 1 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс үргүй зардал гаргасан.	1	15,496.8			1	15,496.8			
Дүн	1	15,496.8			1	15,496.8			
Нийт дүн	2	967,478.2			2	967,478.2			